

**БАТ БӨХИЙН ОРГИЛ,  
БОДИТ ХЭМНЭЛТИЙН ГАЙХАМШИГ**



Way of Life!



**ALL-NEW Jimny**



**ALLGRIP**  
PRO





**Дэлхийн хамгийн өндөр  
оргилын эзэн**



**БАРТААТ ЗАМЫН БААТАР  
БОДИТ ХЭМНЭЛТИЙН ГАЙХАМШИГ**



# ЖИМНИГИЙН ТҮҮХ

1968 онд бартаат замыг туулах гайхалтай чадвартай автомашин бүтээх шинэ санаа Сузукигийн инженерүүдэд орж ирснээр анхны 360cc-тэй HopeStar ON360 нэртэй загвар гарсан билээ. Тэр үеэс хойш бартаат замд тэсвэртэй, туулах чадвар сайтай байх үзүүлэлтийг нь нэмэгдүүлэх зорилгоор олон туршилт шалгалт, алдааны явцад их хэмжээний мэдээлэл цуглуулж чадсанаар бүх төрлийн замд, ямар ч цаг уурын нөхцөлд жолоодох боломжтой өнөөгийн “Жимни” бүтсэн түүхтэй.

Хөгжлийнхөө явцад гурван нэр сольсон бөгөөд Монголчууд “Самурай” нэрийг нь сайн мэднэ. 1998 оноос “Жимни” нэрээр дэлхий дахинд танигдаж, худалдаанд гарч эхэлсэн.



## I-р үеийн Жимни (1970-1981)

1970 оны 04-р сард жижиг оврын автомашинууд дотроос хамгийн анхны 4-н дугуй хөтлөгчтэй Сузуки Жимни нь худалдаанд гарсан. Салхин хөргүүрт 2 цилиндрт 2 тактын цуваа хөдөлгүүртэй бүтээсэн.

## II-р үеийн Жимни (1981-1998)

1981 оны 05-р сард илүү сайжруулалт хийгдсэн 2-р үеийн Сузуки Жимни худалдаанд гарав. Энэ нь усан хөргүүрт 3 цилиндрт 2 тактын хөдөлгүүртэй байсан.

## III-р үеийн Жимни (1998-2018)

1998 оны 10-р сард зөвхөн бартаат замын төдийгүй энгийн үед ч унахад тохиромжтой илүү дэвшилтэт 3-р үеийн загварыг зохион бүтээж худалдаанд гаргав. Усан хөргүүрт 4 цилиндрт, 4 тактын хөдөлгүүртэй байсан.



Шинэ Жимни автомашины их гэрэл, арын гэрлүүд, шаталсан рам гэх мэт олон элементүүд нь хуучны домог болсон Жимнигийн харагдах байдал, явах эд ангиас санаа авсан бөгөөд түүнтэй төсөөтэй байдлаар зохион бүтээгдсэн.

*Дэлхийд борлогдсон нийт тоо: 2.85 сая ширхэг (1970-2018 оны 3 дугаар сар)  
Худалдаалагдсан улс орны тоо: 194 орон*





ALL-NEW **Jimny**










***Nobody but All New JIMNY***



# ҮНДСЭН БҮТЭЦ



## Улам сайжирсан шаталсан рам

Бат бөх шаталсан хэлбэрт раманд амортизаторыг суурилуулж, түүн дээр автомашиныхаа их биеийг байрлуулан, 4WD-ийн уламжлалыг өвлөн авсан шаталсан рамыг ашиглаж байна.

Уламжлал болсон шаталсан раманд "X" хэлбэртэй бэхлэлт нэмж суурилуулсны зэрэгцээ хойд хэсэгт нь хөндлөн бэхлэлт нэмснээр мурийлтад тэсвэртэй байдал нь өмнөх загвараас 1.5 дахин бат бөх болсон.

Мөн их бие болон шаталсан рамыг холбох резиныг дахин шинэчилж сайжруулан зохион бүтээсэн. Энэ нь дээш доош чиглэлд доргилтыг зөөллөж ая тухтай байдлыг бий болгон, жолоодлогын тогтвортой байдлыг сайжруулсан шинэчлэлт нь бас нэгэн хувьсал юм.

## 4-н дугуйгаар зүтгэх систем

Жимнигийн бүх үеийн загваруудын урд, хойд дугуйг энгийн бүтэцтэй тэнхлэгээр шууд холбогдсон байдаг ба шаардлагатай үед 4-н дугуйгаар зүтгэх систем ажиллуулдаг.


Үүний үр дүнд урд болон хойд дугуйны аль нэг нь хий эргэсэн ч зүтгэх хүчээ алдахгүй байх боломжтой.



Жолоодлогын удирдлагын амортизатор

## Жолоодлогын удирдлагын амортизатор

Бартаат замд жолоодлогыг тогтвортой болгосон. Өндөр хурдтай явах үед жолооны хүрд дээр ирэх чичиргээг багасгаж, аюулгүй жолоодлого хийх боломж бүрдүүлсэн.



### 2H(2WD)

Засмал зам, хот дотор, хурдны зам зэрэг энгийн замаар давхих үед.

### 4H(4WD өндөр хурд)

Цастай, шавартай, бартаат замаар 4 дугуйн хөтлөгчтэйгээр давхих үед.

### 4H-L(4WD-L бага хурд)

Хөтлөх хүч хэрэгтэй шавартай зам, гүнзгий устай, хүндрүүлсэн нөхцөлтэй замаар давхих үед.

## Эргэлтийн радиус

4.9м-ийн бага радиуст бүтэн эргэлт хийнэ.

# 4.9м





## Хаана ч үл тулах өнцөг болон тулах цэг

Бартаат замыг туулахад зориулагдсан төгсгөл өнцөг (49°), тулах өнцөг (28°), эхлэл өнцөг (37°), тулах цэг (210mm)–тэй юунд ч үл тулах Жимнигээр адал явдлын гайхамшигийг мэдэрнэ.



Дээрх 3 өнцгөөр бартаат замд туулах чадварыг сайжруулахын тулд эхлэл өнцөг, тулах өнцөг, төгсгөл өнцгийг анхаарч ирсэн бөгөөд тулах цэгийг энэ загварт хамгийн боломжит хувилбар болох 210mm–ийн өндөртэй болгосон. Замын бартаат нөхцөлд ч урд болон хойд их биеийн доод хэсгээрээ шүргэлцэх боломжийг хамгийн бага байхаар нарийн тооцоолж хийсэн.



## 3-н холбоост бат бөх тэнхлэг

Жимни нь уламжлал болсон 3 холбоост бат бөх тэнхлэгээр тоноглогдсон. Зүүн баруун дугуйг шууд холбох хамаарах тэнхлэг нь бусад автомашины үл хамаарах тэнхлэгтэй харьцуулахад бартаа саад ихтэй замд гадаргуутайгаа маш сайн барьцалдаж тогтвортой байдлыг бий болгоно.

1. Амортизатор
2. Пүрш
3. Хөтлөх тэнхлэг
4. Хөндлөн татуурга
5. Урд холбох гар
6. Хойд холбох гар



Front tread(mm)	1,265	
Rear tread(mm)	1,275	
Wheelbase(mm)	2,250	
Suspension method	ӨМНӨ	3 Link Rigid Axle Type Coil Spring
	ХОЙНО	

## Механик удирдлагатай туслах хурдны хайрцаг

Part time 4WD нь замын нөхцөл байдалд тохируулж 2WD болон 4WD өөрөө тохируулан сонгож явах боломжтой. Энэ нь 2H(2WD), 4H(4WD өндөр хурдтай) 4L(4WD бага хурдтай) горимыг тохируулж явах боломжтой механик туслах хурдны хайрцаг юм.

4L бол огцом өгсүүр зам болон бартаатай замаар явахад тохиромжтой болгож энгийн үеэс 2 дахин их хүчээр зүтгэнэ. Жимнигийн 2H $\approx$ 4H $\approx$ 4L араа солих механизм нь шууд араа солигчоор дамжуулагдана.

\* 2H(2WD) $\approx$ 4H(4WD өндөр хурдтай) араа солих үед 100км/ц бага хурдтай давхиж байх үед арааг солих боломжтой.


4L(4WD бага хурдтай) руу араа солих үед машинаа зогсоож байгаад арааг салган арагш татан оруулна.

- 2H 2WD бартаа саадгүй хосолмол замд
- 4H цас, шавар халтиргаатай замд
- 4L хүч шаардлагатай хүндрэлтэй замд





### LSD-систем ажиллаагүй үед



Баруун урд, зүүн хойд дугуй хий эргэсэн тохиолдолд зүүн урд дугуй болон баруун хойд дугуйны зүтгэх хүч нь алдагдана.

### LSD-систем ажиллаатай үед



#### 4L(4WDбага хурд)

Хий эргэж байгаа дугуйг тоормослож зүүн урд дугуй болон баруун хойд дугуйны зүтгэх хүчийг алдагдахгүй байлгана.

### Тоормос LSD жолоодлогын удирдлага

4WD горимд шилжсэн байсан ч баруун зүүн дугуйны аль нэг нь хий эргэсэн тохиолдолд нөгөө талын дугуйны зүтгэх хүч нь алдагддаг. Ийм үед зүтгэх хүчийг хадгалахын тулд Жимни нь цахим хяналттай LSD тоормосны системээр тоноглогдсон. Зүтгэх горимыг 4L болгон солиход зөвхөн хий эргэж байгаа дугуйнд л тоормос үйлчилнэ. Хөдөлгүүрийн эргэлтийн хурдыг бууруулаагүй тул эсрэг талын дугуй урагш зүтгэх хүчээ алдалгүй бартааг даван туулах чадвар өндөртэй байна.

Хөдөлгүүрийн эргэлтийн хурдыг бууруулаагүй тул бусад дугуйны жолоодлогыг найдвартай хамгаалж, зүтгэх хүчийг өндөр байлгана.



ESP(R)OFF товч

\*4L-р явж байх үед ESP(R)OFF товчийг удаан дарсанаар Hill hold control -ийг салгаж болно.



Hill descent control

\*Уруу замын хяналтын системийн товчлуурыг ON болгон араа шилжүүлэгчийг 4H, 4L горимд тохируулж 25км/ц доош хурдтай, 7%-налуутай газар ажиллаж эхэлнэ. Автомат хурдны хайрцагтай АТ машин дээр Р ба N гэсэн горимд ажиллахгүй.

### Өгсүүр замын хяналт (Hill Hold control)

Өгсүүр замд хөдөлгөөн эхлэх үед тормосноос хөлөө салган, хаазан дээр гишгэх хооронд түр зуур тоормосноос ажиллах систем хамгийн удаандаа 2 секунд машин хойш ухрахгүй зөөлнөөр хөдөлгөөнөө эхэлж болно.

Механик болон автомат кроптойд адилхан стандартаар тоноглогдсон байдаг.

### Уруу замын хяналтын систем (Hill descent control)

Огцом уруу замд автомат тоормосны хяналтын систем ажиллаж, хурд авахыг барьж, тогтмол нэг хурдаар явах боломжийг олгосноор анхаарлаа төвлөрүүлж аюулгүй жолоодно.

### Хурд хянах систем (XC)-Cruise control system

Тогтмол хурд баригч (45км/цаг – 100км/цаг хүртэл) автомат хурдны тохируулгатай (cruise control) төхөөрөмжөөр тоноглогдсон.

Хааз байнга гишгэж явах шаардлагагүй тогтмол хурдтай давхих болон холын замд тав тухтай жолоо барих боломжтой.





## Хөдөлгүүр



Хүчирхэг 1.5 литрийн хөдөлгүүр нь RPM буюу нэг минутын шилжилтийн хүчээр өндөр мушгих хүчийг бий болгож бартаат замд туулах чадварыг сайжруулсан.

Мөн жижиг хэмжээтэй, хөнгөн жинтэй учраас бензин зарцуулалтыг хамгийн бага түвшинд хүргэсэн.


## Хурдны хайрцаг



Механик хурдны хайрцаг буюу 5MT нь араа шилжүүлэхэд хялбар, спортлог мэдрэмжийг төрүүлж, чичиргээ болон эсэргүүцлийг багасгаж түлш зарцуулалтад хэмнэлттэй.

4AT нь араа солих үйл ажиллгааг илүү хялбар эвтэйхэн болгохын тулд шулуун хэлбэрийн араа ашигласан. Атгахад эвтэйхэн бариул, араа солилтын тэмдэглэл харагдах байдлыг сайжруулсан зэрэг нь удирдахад хялбар болжээ.

### Бартаат замын гүйцэтгэл, чимээгүй ажиллагааны хослол



Шалыг бүхэлд нь хэвэнд оруулсан эсгийгээр бүрснээр замын болон араа дамжуулалтын дуу чимээг багасгана.

Бүхэлд нь доргио шингээгч резинээр бүрснээр моторын дууг багасгана.



### Араа шилжүүлэгчийн чичиргээг багасгах бүтэц

Араа шилжүүлэгчийн эд ангийг автомашины их биед 2 дамжуулагч + 1 босоо тулгуур хэлбэрээр суурьлуулан өгснөөр араа шилжүүлэгчийн чичиргээг багасгасан.





Нүүрний хэсгийн бат бөх байдлыг нэмэгдүүлсэн.



Шилний гадаргуу дээр цас, тоос тогтохооргүй тэгш дөрвөлжин биетэй.



Бартаат замд бат бөх байдлыг мэдрүүлэх урд гупер.



Бартаат замд бат бөх байдлыг мэдрүүлэх хойд гупер.



# Автомашины ертөнцөд хувьсал авчирлаа.



Дугуй солиход төвөгшил багатай, дугуйн тасалгаатай.



Туулах чадварыг нэмэгдүүлсэн гүпертэй.





5 тасалгаатай хамар, дугуй хэлбэртэй их гэрэл, бие даасан дохионы гэрэл.





## Дотоод интерьерийг энгийн бүтэцтэйгээр шийдсэн

Урд хаалганы толины хэсэг орчмыг доош болгож өгснөөр харагдах талбайг томруулсан нь интерьер дизайн тал дээр ч хэрэглэхэд дөхөм болгож байна.



### Шинэчлэгдсэн дотор салон

Хянах хэсэгт гэрэл ойлтыг багасгаж, сэв зураас бохирдолт мэдэгдэхээргүй гадаргууг боловсруулан хийж өгсөн.



**Дөрвөлжин хэлбэрийн хянах самбар дээр хэрэгтэй хэмжигчийг энгийнээр багтаасан.** Үйл ажилгаанд анхаарсан энгийн дизайнтай. Ямар ч үед харах боломжтой байнгын гэрэлтүүлэгтэйгээс гадна гол хэсэгтээ олон мэдээлэл дамжуулах дэлгэцтэй.



Баруун зүүн цонхны товчлуур, голд нь ESP(R)OFF товчлуур болон уруудалтын хяналтын товчлуурыг суурьлуулж өгсөн. Бээлийтэй гараар удирдахад хялбар болгосон том хэмжээтэй товчлуурыг суурилуулсан.





### Тухлаг бөгөөд аюулгүй байдлыг хангасан суудал

Урд суудал 10мм-ийн жижигхэн хөшүүргээр нааш цааш 240мм зайд шилжих боломжтой. Баруун, зүүн талын суудлууд бүрэн бие даасан байх бөгөөд 12 түвшинд тохируулж болдог учраас холын аялалд ядрахгүй.



### Бүх гадаргуу, хэт ягаан туяаны хамгаалалт бүхий шил

Салхины шил болон цонхнууд нь хэт ягаан туяаны хамгаалалттай бөгөөд хурц нартай үед нүд гялбахгүй жолоодох боломжтой.



### Үзэгдэх орчин

А үсгийн хэлбэртэй баганан дизайнаар харагдах өнцгийг улам нэмэгдүүлсэн. Мөн машины хамрын тэгш байдал нь харагдах байдлыг нэмэгдүүлж өгсөн.



### Хаалганы бариул

Атгахад хялбар том хэмжээтэй



### Жинхэнэ арьсаар бүрсэн жолооны хүрд

Жолооны хүрдийг 35мм-ээр дээш доош байрлалд тохируулснаар жолоодлого хийхэд тав тухтай болгосон.





Зорчигчийн суудлын налуурыг хэвтүүлбэл 377 (+53) литрийн багтаамжтай ачаа багтах зай үүснэ. Арын хаалганы онгойх хэсэг нь том бөгөөд ачаа ачих, буулгахад хялбар. Шал нь бүрэн хавтгай байх бөгөөд дөрвөлжин орон зайг үүсгэсэнээр ашиггүй талбай огт байхгүй болсон. Мөн ашиглалтыг улам сайжруулах зорилгоор ачаа тогтоох дэгээгээр тоноглогдсон.



### Суудлын тохируулга

Урд талын суудлын налуурыг хойш хэвтүүлбэл тэгш талбай үүсэх ба машин дотроо чөлөөтэй амарч болно. Хойд суудлын налуурыг хойш налуулж илүү уужим зай үүсгэх боломжтой.



### Арын суудлын бүс

Арын суудлын бүсний тохируулгатай. Бүсийг хэрэглэхгүй үед далдлан богиносгох боломжтой тул арын хэсэгт ачаа ачих үед саад болохгүй.



### Ачааны болон багаж хэрэгслийн хайрцаг

Ачааны хайрцаг нь тагтай бөгөөд жижиг эд зүйлс зэргийг хийж хадгалах боломжтой. Энэхүү хайрцагны доод талд багаж хэрэгслийн хайрцагийг байрлуулжээ.



### Эд зүйл хийх зай багтаамж

Голын хэсэгт гар утас, жижиг овортой эд зүйлс хийх тасалгаатай.



### Борооны хамгаалалт


Хаалгыг онгойлгох үед машины дээвэр дээрх усны дусал, борооны ус дотогш орохоос хамгаалан жижиг хэмжээний саравчийг дээвэрт байрлуулжээ.



### Ачааны хэсгийн нэмэлт тоноглол

Арын суудлын зүүн талд 12 вольтын залгуураар тоноглогдсон. Арын хаалга баруун тийш онгойх ба ачаа ачихад тохируулан зүүн талд нь ачааны уяа тогтоох гогцоо хийж өгчээ.





### Урд болон хажуугийн бэхжүүлсэн хамгаалалт

Ослын үед хамгийн ихээр гэмтэх магадлалтай толгой, хөлний гэмтлийг хамгийн бага байхаар тооцоолж машины урд хэсгийн эд ангиудыг бэхжүүлсэн.

1. Доргилтод тэсвэртэй шил арчигч
2. Доргилтод тэсвэртэй урд хаалт
3. Доргилтод тэсвэртэй капутны нугас
4. Доргилтод тэсвэртэй крыло
5. Доргилтод тэсвэртэй копот
6. Доргилтод тэсвэртэй урд бампер



### Ослын дэр

Гэнэтийн аюул ослыг нарийвчлан тооцож үзэн жолооч болон урд талын зорчигчийн, хажуугийн SRS ослын дэрийг суурилуулж өгсөн.



Front wheel slippage

Rear wheel slippage



### Шарвалтын эсрэг систем / Brake LSD Traction Control/

Хэрэв диагональ /хөндлөн/ дугуйны аль нэг нь замтай харилцах зууралтаа алдвал энэ систем нь хальтиргаа үүссэн дугуйны тоормосыг автоматаар идэвхжүүлж үлдсэн 2 дугуйны эргэх хөдөлгөөнийг жигдрүүлэн аюулаас хамгаалдаг.



## ДАН ӨНГӨ



Цагаан | Superior white



Мөнгөлөг | Silky silver metallic



Хар саарал | Medium gray



Сувдан хар | Bluish black pearl



Ширэнгэн ойн ногоон |  
Jungle green

## ХОСОЛСОН ӨНГӨ



Хул шар | Chiffon ivory metallic







Тод шар | Kinetic yellow



Хөх | Brisk blue metallic

### SUZUKI NEW JIMNY автомашины техник үзүүлэлт

Жолоодлогын хүрдний байрлал	Зүүн талд
Хаалганы тоо	3
Жолоодлогын систем	ALLGRIP PRO
Хөдөлгүүрийн код	K15B
Хөдөлгүүрийн төрөл	4 цилинדר   VVT
Хөдөлгүүрийн багтаамж (см3)	1462
Дээд хүчин чадал (квт/мин)	75/6000
Дээд эргүүлэх хүч (Нм/мин)	130/4000
Хурдны хайрцаг	5-шатлалт механик 4-шатлалт автомат
Шатахууны төрөл	Бензин
Шатахууны савны багтаамж(л)	40
Газраас тэнхлэг хүртэлх зай (мм)	210
Эргэлтийн радиус (м)	4.9
Тэнхлэг хоорондын зай (мм)	2250
Шатахуун зарцуулалт	100км/8-10литр
Дугуй	195/80R15
Тоормос	Урд: Диск Хойд: Клодкон
Тэнхлэг	Урд: Хамаарах Хойд: Хамаарах
Суудлын тоо	4





ALLGRIP  
PRO



ALL-NEW **ЖИИЦ**

*Автомашины ертөнцөд хувьсал авчирлаа.*





## БРИДЖ КОРПОРАЦИ


Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө,  
Улаанбаатар-51, Монгол Улс.

Худалдааны төлөөлөгч: 99015533, 99065533

Сузуки сэлбэг, засвар үйлчилгээний төв: 70005570, 94010110, 99000110

[www.bridgecorporation.mn](http://www.bridgecorporation.mn)

 Suzuki Mongolia

 Suzuki\_Mongolia

 Suzuki\_Mongolia\_Official

 Bridge Corporation